



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/217

Булган сум

Мах нийлүүлэх ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.5, Засгийн газрын 2023 оны 344 дүгээр тогтоолоор батлагдсан “Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зарцуулах журам”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны хуралдааны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2.3.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/203 дугаар захирамжаар байгуулагдсан “Мах бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгж, иргэнийг сонгон шалгаруулах ажлын хэсэг”-ийн 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу Булган сумын хүн амын 2024 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд мах бэлтгэн нийлүүлэхээр шалгарсан “Өнө мөнх бадрах” хоршоотой гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т үүрэг болгосугай.

2. Бэлтгэн нийлүүлж байгаа махны чанар, эрүүл ахуй аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

3. Худалдаанд нийлүүлж байгаа махны өдөр тутмын гүйцэтгэлд хяналт тавьж, тооцоо нийлж ажиллахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр), явцын болон гүйцэтгэлийн хяналтыг ажлын хэсэг (Г.Давааням)-д даалгасугай.

4. Гэрээний дагуу бэлтгэн нийлүүлсэн 1 кг мах тутамд 2000 (хоёр мянга) төгрөгийн урамшууллыг аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжаар батлагдсан “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал”-ын 20-д тусгагдсан Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010295